



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 12 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 12 дугаар хуралдааныг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан.

Зохицуулах хорооны 2025 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар /2025-05-29/ ХХЗХ-ноос 2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай; Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн тухай зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 13 (Тогтоол №115-127, 2025-05-29) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд тусгай өргөн нэвтрүүлгийн (ӨН) зөвшөөрөл олгохдоо техник, технологийн дэвшил, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, эрх ашигт нийцүүлэн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зарчмыг баримтлах, мөн ӨН-ийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгаанд үндэслэх, Олон нийтийн ТВ, төлбөртэй телевизээс бусад ТВ, ОСДҮЭ, газрын сүлжээний үйлчилгээг сонгон шалгаруулалтаар олгоно. ХХЗХ-ны бүрэн эрх нь ӨНҮЭ-ийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж, жил бүр үнэлэлт, дүгнэлт гаргах, ӨН-ийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний талаар судалгаанд үндэслэн ТЗ-ийн тоог тогтооно гэж заасан байдаг. Тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний төрөл, тоог тогтоохдоо одоо байгаа ТЗ-эзэмшигчдийн тоо, өмнөх онуудад шинээр олгосон олгосон тусгай зөвшөөрлийн тоо, ХХЗХ-нд ирсэн хүсэлт, судалгаа, Аймаг орон нутагт өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ хүлээн авч буй байдал, хэрэглэгчийн тоо, нэвтрэлт, Үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүдийн хөтөлбөрийн байдал – тухайлбал-Спортын г.м; Зах зээлийн багтаамж, өрсөлдөөний нөхцөл байдлыг авч үзэхдээ тухайн хамрах хүрээний хүн ам, өрхийн тоо, хүн амын нягтрал, тухайн хамрах хүрээн дэх үйлчилгээ эрхлэгчдийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдал, орлого, зардлын судалгаа- Радиоогийн хувьд радио, давтамжийн төлөвлөлт, нөөц, сувгийн багтаамжийн судалгаа зэргийг авч үздэг. ӨНЗГ-ын ажлын хэсгээс Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, өрсөлдөөний нөхцөл байдлыг тодорхойлох судалгааны аргачлал (Хорооны даргын 2022 оны А/105 тоот тушаалыг баримталжээ. Тус хуралдаанаар ХХЗХ-ноос 2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай танилцуулга (Үүнд, Улаанбаатар хот, тухайн аймаг бүрд олгох тоо: Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл), тогтоолын төслийг тус тус хэлэлцээд, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтыг үндэслэн Хорооны 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 115 тоот “Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо батлах тухай”

тогтоолыг батлав. Энэхүү тогтоолын хавсралтаар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоон шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 12 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар олгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлтийн болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 12 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 12 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 116 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар нэр бүхий 4 хуулийн этгээдэд 4 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 117 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Азийн зам ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс – БНХАУ/; Эн Экс Би смарт ложистик ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс – БНХАУ/) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 118 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Хурд онцгой боломж карго ХХК: “Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 119 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Бинчин хүү ХХК, 43200124 тоот: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс–БНСУ/) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 120 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Ашид талиман ХХК, 12100648 тоот болон Юнайтед эй энд и телекоммуникэйшн нетворк ХХК, 12100434 тоот: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх”) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт,

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 121 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Дөрвөн шарга ХХК: Увс аймгийн нутаг дэвсгэрт “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” 13400036 тоот) сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1.1, 1.3 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12.1, 14.12.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 122 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 90 хоногийн хугацаагаар (Төгс барчин хангай ХХК: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл” 12900345 тоот тусгай зөвшөөрлийг) түдгэлзүүлсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Сод электроникс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 123 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Сод электроникс ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх” 13600175 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Бодь-орчин ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 124 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Бодь-орчин ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100729 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Шагнаа ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 125 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Шагнаа ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200192 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 126 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд 2 харилцаа холбооны сүлжээний дугаарыг (Мэдээллийн аюулгүй байдлын газар: 1800-1118; Цагдаагийн ерөнхий газрын авто бааз: 1800-2520) 2 жилийн хугацаатай шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 127 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 8 хуулийн этгээдийн 8 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтыг 2 жилийн хугацаатай сунган тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-06-09